



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 18 (591)

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- *Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай*

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- *Татварын алдангийн хувь хэмжээг тооцох тухай*
- *Татварын маргаан таслах зөвлөлийн ажиллах журам батлах тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот

2009 он



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Долоо хоног тутмын хэвлэл

2009 оны тавдугаар сарын 11 №18 (591)

Улаанбаатар хот

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- | | | |
|------|---|-----|
| 239. | Төрийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | 415 |
| 240. | Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | 416 |

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- | | | | |
|------|--|-----------|-----|
| 241. | Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай | Дугаар 31 | 416 |
|------|--|-----------|-----|

Гурав. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

- | | | | |
|------|--|-----------|-----|
| 242. | Чинбатын Бат-Эрдэнэд Монгол Улсын гавьяат жүжигчин цол хүртээх тухай | Дугаар 75 | 416 |
| 243. | Цэдэнгийн Гарамжавт Монгол Улсын аж үйлдвэрийн гавьяат ажилтан цол хүртээх тухай | Дугаар 76 | 416 |
| 244. | Дугарын Тунгалагт Монгол Улсын аж үйлдвэрийн гавьяат ажилтан цол хүртээх тухай | Дугаар 77 | 417 |
| 245. | Чимэддоржийн Ганхуягт Монгол Улсын урлагийн гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай | Дугаар 78 | 417 |
| 246. | Ганбаатарын Хонгорзүлд Монгол Улсын гавьяат жүжигчин цол хүртээх тухай | Дугаар 79 | 417 |
| 247. | Лхагвын Чинбатад Монгол Улсын ХАА-н гавьяат механикжуулагч цол хүртээх тухай | Дугаар 80 | 417 |
| 248. | Отгоны Доржид Монгол Улсын гавьяат малчин цол хүртээх тухай | Дугаар 81 | 418 |
| 249. | Дангаажавын Баттулгад Монгол Улсын гавьяат тамирчин цол хүртээх тухай | Дугаар 82 | 418 |

Дөрөв. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- | | | | |
|------|--|-----------|-----|
| 250. | Хууль тогтоомж, шүүх эрх мэдлийн эрдэм шинжилгээ, сургалт, мэдээлэл, сурталчилгааны үндэсний төвийг өөрчлөн зохион байгуулах тухай | Дугаар 18 | 418 |
| 251. | Түлш, эрчим хүчээр үйлдвэрүүдийн талаар авах зарим арга хэмжээний тухай | Дугаар 20 | 418 |
| 252. | Татварын алданийн хувь хэмжээг тооцох тухай | Дугаар 21 | 420 |
| 253. | Татварын маргаан таслах зөвлөлийн ажиллах журам батлах тухай | Дугаар 22 | 420 |

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУУЛЬ

2009 оны 03 дугаар сарын 12-ны өдөр

ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Улаанбаатар хот

1 дүгээр зүйл. Төрийн албаны тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсгийн "төрийн жинхэнэ албан хаагчид 36 сарын" гэснийг "төрийн жинхэнэ албан хаагчид төрийн албанд ажилласан хугацааг харгалзан 36 хүртэл сарын" гэж, 38 дугаар зүйлийн 38.2 дахь хэсгийн "Төрийн албаны" гэснийг "Улс орныг хамарсан санхүү, эдийн засгийн хямралыг даван туулах онцгой арга хэмжээ авахаас бусад тохиолдолд төрийн албаны" гэж тус тус өөрчилсүгэй.

(Тайлбар: Улсын Их Хурлын 2009 оны 3 дугаар сарын 12-ны өдөр баталсан Төрийн албаны тухай

хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйлийн Төрийн албаны тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.2 дахь хэсэгт оруулах заалтад Монгол Улсын Ерөнхийлөгч 2009 оны 3 дугаар сарын 25-ны өдөр хэсэгчлэн хориг тавьсан.

Улсын Их Хурал хоригийг хүлээн авч 2009 оны 4 дүгээр сарын 09-ний өдөр дээрх хуульд өөрчлөлт оруулах тухай хууль баталсан)

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2009 оны 3 дугаар сарын 13-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУУЛЬ

2009 оны 04 дүгээр сарын 16-ны өдөр

Улаанбаатар хот

УЛС ТӨРИЙН ХИЛС ХЭРЭГТ ХЭЛМЭГДЭГЧДИЙГ ЦАГААТГАХ, ТЭДЭНД НӨХӨХ ОЛГОВОР ОЛГОХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэг, 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсгийн "2009 оны 2 дугаар сарын 1-

ний дотор" гэснийг "2011 оны 12 дугаар сарын 30-ны дотор" гэж тус тус өөрчилсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2009 оны 04 дүгээр сарын 16-ны өдөр

Дугаар 31

Улаанбаатар хот

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан улсын төсвөөс гаргах нэмэгдэл зардлыг Монгол Улсын 2009 оны батлагдсан төсөвт нэмж тусган хэрэгжүүлэх арга хэмжээ авахыг Засгийн газар /С.Баяр/-т даалгасугай.

2. Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийн талаархи архивын материалыг түргэн хугацаанд хянан боловсруулах үүднээс Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын ажлын албанд гэрээт ажилтан авч ажиллуулах асуудлыг судлан үзэж, холбогдох зардлыг Монгол Улсын 2009 оны батлагдсан төсөвт

нэмж тусган хэрэгжүүлэх арга хэмжээ авахыг Засгийн газар /С.Баяр/-т үүрэг болгосугай.

3. Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдэд хуульд заасны дагуу олгож байгаа нөхөх олговрын хэмжээг эдийн засаг, нийгмийн өнөөгийн түвшинд нийцүүлэх асуудлыг судлан үзэж, санал, дүгнэлтийн хамт Улсын Их Хуралд танилцуулахыг Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комисс /Н.Энхболд/-т даалгасугай.

4. Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуулийн биелэлтийг Улсын Их Хурлын 2011 оны намрын ээлжит чуулганд танилцуулахыг Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комисс /Н.Энхболд/-т даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2009 оны 03 дугаар сарын 13-ны өдөр

Дугаар 75

Улаанбаатар хот

Чинбатын Бат-Эрдэнэд Монгол Улсын гавъяат жүжигчин цол хүртээх тухай

"Хонхны нулимс", "Чи минь дэргэд байвал би жаргалтай", "Цагаан сүүний ургамал" зэрэг шилдэг уран бүтээлүүдээ олон түмний хүртээл болгож, орчин үеийн нийтийн дуу дуулаачдын менежментийг өөрчлөн шинэчилж, Монголын соёл урлаг, түүний дотроос мэргэжлийн болон нийтийн дууны урлагийн хөгжилд

оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж дуучин Чинбатын Бат-Эрдэнэд Монгол Улсын гавъяат жүжигчин цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2009 оны 03 дугаар сарын 13-ны өдөр

Дугаар 76

Улаанбаатар хот

Цэдэнгийн Гарамжавт Монгол Улсын аж үйлдвэрийн гавъяат ажилтан цол хүртээх тухай

Геологи, уул уурхайн салбарт үр бүтээлтэй ажиллаж, уул уурхайн үйлдвэрлэлд орчин үеийн шинэ техник, технологийг нэвтрүүлэн, бүтээмжийг дээшлүүлж, ажлын байрыг нэмэгдүүлэн, улсын эрдэнэсийн санг баяжуулж Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжилд

оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж "Монполимет" ХХК-ийн ерөнхий захирал Цэдэнгийн Гарамжавт Монгол Улсын аж үйлдвэрийн гавъяат ажилтан цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2009 оны 03 дугаар
сарын 13-ны өдөр

Дугаар 77

Улаанбаатар
хот

**Дугарын Тунгалагт Монгол Улсын аж
үйлдвэрийн гавъяат ажилтан цол хүртээх тухай**

Хүнсний аж үйлдвэрийн салбарт үр бүтээлтэй ажиллаж, орчин үеийн шинэ техник технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлэн, үндэсний шинэ нэр төрлийн экологийн цэвэр бүтээгдэхүүнийг бий болгож хүн амын хүнсний хэрэгцээг хангах, гадаад зах зээлд гаргах, хүнсний үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд оруулж байгаа хувь

нэмрийг нь үнэлж, үйлдвэрлэл, худалдааны "Бенедакт" ХХК-ийн ерөнхий захирал Дугарын Тунгалагт Монгол Улсын аж үйлдвэрийн гавъяат ажилтан цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2009 оны 03 дугаар
сарын 13-ны өдөр

Дугаар 78

Улаанбаатар
хот

**Чимэддоржийн Ганхуягт Монгол
Улсын урлагийн гавъяат зүтгэлтэн цол хүртээх тухай**

Соёл урлагийн салбарт олон жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж, үндэсний драмын болон дуулалт жүжиг, концерт, төрийн ёслол хүндэтгэлийн арга хэмжээнүүдийг тайзнаа чадварлаг найруулан тавьж, дуулалт жүжигт найруулгын өвөрмөц зохиомж, шинэлэг арга барил нэвтрүүлэн, орчин үеийн театрын урлагийг

хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Төв аймгийн "Монгол туургатан" театрын захирал, уран сайхны удирдаач Чимэддоржийн Ганхуягт Монгол Улсын урлагийн гавъяат зүтгэлтэн цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2009 оны 03 дугаар
сарын 13-ны өдөр

Дугаар 79

Улаанбаатар
хот

**Ганбаатарын Хонгорзулд Монгол
Улсын гавъяат жүжигчин цол хүртээх тухай**

Соёл урлагийн салбарт үр бүтээлтэй ажиллан, Монгол ардын уртын дууг чадварлаг дуулан үзэгч олны хүртээл болгож, Монголын соёл урлаг, түүний дотроос үндэсний бахархал болсон уртын дууны урлагийг хөгжүүлэх, дэлхий дахинд сурталчлан таниулахад оруулж

байгаа хувь нэмрийг нь үнэлж Нийслэлийн "Улаанбаатар" чуулгын дуучин Ганбаатарын Хонгорзулд Монгол Улсын гавъяат жүжигчин цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2009 оны 03 дугаар
сарын 13-ны өдөр

Дугаар 80

Улаанбаатар
хот

**Лхагвын Чинбатад Монгол Улсын
ХАА-н гавъяат механикуулагч цол хүртээх тухай**

Хөдөө аж ахуйн салбарт томоохон хэмжээний хөрөнгө оруулалт хийж, өндөр хүчин чадалтай орчин үеийн техник, шинэ технологи нэвтрүүлэн, усалгаатай тариалангийн талбайг нэмэгдүүлж, жил бүр тогтвортой өндөр ургац хураан, газар тариалангийн үйлдвэрлэлийг сэргээх, эрчимжсэн газар тариалан, мал аж ахуйг

хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Сэлэнгэ аймгийн "Гацуурт" ХХК-ийн ерөнхий захирал Лхагвын Чинбатад Монгол Улсын ХАА-н гавъяат механикуулагч цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2009 оны 03 дугаар сарын 13-ны өдөр

Дугаар 81

Улаанбаатар хот

Отгоны Доржид Монгол Улсын гавъяат малчин цол хүртээх тухай

Мал сүргээ жил бүр тогтвортой өсгөн үржүүлж, малын чанар, үүлдэр угсааг сайжруулах, малаас авах ашиг шимийг нэмэгдүүлэх, залуу малчдыг мал маллагааны арга ухаанд сургах, иргэдийг малжуулах, мал аж ахуйн үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд оруулж байгаа

хувь нэмрийг нь үнэлж Архангай аймгийн Хайрхан сумын Асгат багийн малчин Отгоны Доржид Монгол Улсын гавъяат малчин цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2009 оны 03 дугаар сарын 13-ны өдөр

Дугаар 82

Улаанбаатар хот

Дангаажавын Баттулгад Монгол Улсын гавъяат тамирчин цол хүртээх тухай

Хөнгөн атлетикийн спортын төрлөөр тив дэлхий, олон улсын хэмжээний болон улсын аварга шалгаруулах тэмцээнүүдэд тогтмол амжилттай оролцож, Ази тивийн мастеруудын аваргын алтан медаль 5 удаа, "Ринго"-гийн дэлхийн аваргын анхны алтан медаль хүртсэн амжилтыг нь үнэлж Зэвсэгт хүчний "Алдар" спорт хорооны

тамирчин, хөнгөн атлетикийн спортын олон улсын хэмжээний мастер Дангаажавын Баттулгад Монгол Улсын гавъяат тамирчин цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2009 оны 01 дүгээр сарын 21-ний өдөр

Дугаар 18

Улаанбаатар хот

Хууль тогтоомж, шүүх эрх мэдлийн эрдэм шинжилгээ, сургалт, мэдээлэл сурталчилгааны үндэсний төвийг өөрчлөн зохион байгуулах тухай

Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 6.1.7, 11.2.1-ийг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа Хууль тогтоомж, шүүх эрх мэдлийн эрдэм шинжилгээ, сургалт, мэдээлэл, сурталчилгааны үндэсний төвийг Хууль зүйн үндэсний хүрээлэн болгон өөрчлөн зохион байгуулсугай.

2. Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн дүрэм, орон тооны хязгаарыг баталж мөрдүүлэхийг Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдоржид зөвшөөрсүгэй.

3. Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн үйл ажиллагааны зардлыг Хууль зүй, дотоод хэргийн сайдын төсвийн багцад тусган санхүүжүүлж байхыг Сангийн сайд

С.Баярцогт, Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж нарт тус тус даалгасугай.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулж "Хууль тогтоомж, шүүх эрх мэдлийн эрдэм шинжилгээ, сургалт, мэдээлэл, сурталчилгааны үндэсний төв байгуулах тухай" Засгийн газрын 2002 оны 6 дугаар сарын 18-ны өдрийн 121 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

С.БАЯР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД Ц.НЯМДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2009 оны 01 дүгээр сарын 21-ний өдөр

Дугаар 20

Улаанбаатар хот

Түлш, эрчим хүчний үйлдвэрүүдийн талзар Авах зарим арга хэмжээний тухай

Түлш, эрчим хүчний үйлдвэрүүдийн хэвийн, найдвартай ажиллагааг хангаж, түлш, эрчим хүчний хангамжийг сайжруулах зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Сангийн сайд С.Баярцогт, Эрдэс баялаг, эрчим хүчний

сайд Д.Зоригт, Төрийн өмчийн хороо (Д.Сугар)-нд тус тус үүрэг болгосугай:

а) "Дулааны IY цахилгаан станц" ХК-ийн аюулгүй ажиллагааг хангах зорилгоор тус станцын генераторын 10 кВ-ын тосон таслуурыг шинэчлэхэд шаардагдах 1.5 (нэг тэрбум таван зуун сая) тэрбум төгрөгийг Монгол Улсын 2009 оны төсвийн тухай хуульд

нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусган шийдвэрлэх арга хэмжээ авах;

б) тулш, эрчим хүчний үйлдвэрүүдэд 2010-2012 онд хийх хөрөнгө оруулалтын арга хэмжээнд шаардагдах 259.2 (хоёр зуун тавин есөн тэрбум хоёр зуун сая) тэрбум төгрөгийг энэхүү тогтоолоор баталсан хавсралтын дагуу жил бүрийн улсын төсөвт тусган, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

в) Улсын Их Хурлын 2008 оны 47 дугаар тогтоолын хавсралтаар баталсан өөрийн хөрөнгөөр гүйцэтгэн дараа төлөгдөх нөхцөлтэйгээр барих авто зам, эрчим хүчний барилга байгууламжийн жагсаалтын 2 дахь хэсгийн 12, 13 дахь заалтаас Улаанбаатар хотын кабель шугамын шинэчлэлт, кабель шугамыг сувагт оруулах ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай 9.1 (есөн тэрбум нэг зуун сая) тэрбум төгрөгийн хөрөнгийг хасах асуудлыг зохих журмын дагуу шийдвэрлүүлж, Монгол Улсын 2009 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгах арга хэмжээ авах;

г) Багануур, Шивээ-Овоогийн нүүрсний уурхайд нэн тэргүүнд хийх шаардлагатай техникийн шинэчлэлийг эхлүүлэхэд шаардагдах 34.0 (гучин дөрвөн тэрбум) тэрбум төгрөгийн хөрөнгийн эх үүсвэрийн 12.4 (арван хоёр тэрбум дөрвөн зуун сая) тэрбум төгрөгийг Монгол Улсын 2009 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгах, үлдсэн 21.6 (хорин нэгэн тэрбум зургаан зуун сая) тэрбум төгрөгийг шинээр хувьцаа гаргах замаар санхүүжүүлэх асуудлыг зохих журмын дагуу шийдвэрлүүлэх.

2. "Нүүрсний аюулгүйн нөөц"-ийг бий болгох эрх зүйн орчин бүрдүүлэх талаар санал боловсруулж Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригт, Монгол Улсын

Шадар сайд М.Энхболд нарт даалгасгай.

3. 2009-2010 оны өвлийн их ачааллын үеэс эхлэн төрийн өмчит дулааны цахилгаан станцуудад "Нүүрсний аюулгүйн нөөц" бүрдүүлэх арга хэмжээ авч, түүнд шаардагдах 5,302.0 (таван тэрбум гурван зуун хоёр сая) сая төгрөгийн эх үүсвэрийг Монгол Улсын 2009 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгах болон бусад боломжийг судалж, шийдвэрлүүлэхийг Сангийн сайд С.Баярцогт, Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригт нарт даалгасгай.

4. Багануур, Шивээ-Овоогийн нүүрсний уурхайн санхүүгийн хүндрэлтэй байдлыг харгалзан Сангийн яам болон эдгээр уурхайн хооронд байгуулсан дамжуулан эзэлдүүлэх гэрээний дагуу "Багануур" ХК-ийн 2007-2011 онд төлөх зээлийн нийт төлбөрийн 50 хувь, "Шивээ-Овоо" ХК-ийн 2008-2012 онд төлөх зээлийн нийт төлбөрийн 50 хувийн хугацааг тус тус хойшлуулах арга хэмжээ авахыг Сангийн сайд С.Баярцогт, Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригт нарт зөвшөөрсүгэй.

5. Эрчим хүчний зориулалтаар нийлүүлэх нүүрсний үнийг уурхайн санхүүгийн бие даасан байдлыг хангах хэмжээнд холбогдох хууль тогтоомжийн дагуу хянаж байх, цахилгаан, дулааны үнэ тарифыг индексжүүлэх эрх зүйн орчин бүрдүүлэх талаар санал боловсруулж шийдвэрлүүлэх зэрэг арга хэмжээ авахыг Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригт даалгасгай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАЯР

**ЭРДЭС БАЯЛАГ, ЭРЧИМ
ХҮЧНИЙ САЙД**

Д.ЗОРИГТ

**Засгийн газрын 2009 оны 20 дугаар
тогтоолын хавсралт**

**ТУЛШ, ЭРЧИМ ХҮЧНИЙ ҮЙЛДВЭРҮҮДЭД 2010-2012 ОНД ХИЙХ
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТАД ШААРДАГДАХ ХӨРӨНГИЙН ХЭМЖЭЭ
/сая төгрөг/**

№	Компанийн нэр	Онууд			Нийт дүн
		2010	2011	2012	
1	"Багануур" ХК	16,500.0	7,800.0	7,400.0	31,700.0
2	"Шивээ-Овоо" ХК	8,300.0	25,700.0	6,900.0	40,900.0
3	"Дулааны IY цахилгаан станц" ХК	20,200.0	9,374.4	-	29,574.4
4	"Дулааны III цахилгаан станц" ХК	6,650.0	21,000.0	25,000.0	52,650.0
5	"Дулааны II цахилгаан станц" ХК	4,300.0	-	-	4,300.0
6	"Дарханы Дулааны цахилгаан станц" ХК	5,450.0	5,450.0	2,970.0	13,870.0
7	"Эрдэнэтийн Дулааны цахилгаан станц" ХК	1,900.0	3,800.0	1,900.0	7,600.0
8	"Төвийн бүсийн цахилгаан дамжуулах сүлжээ" ХК	9,940.0	2,000.0	-	11,940.0
9	"Улаанбаатарын цахилгаан түгээх сүлжээ" ХК	10,941.6	3,200.0	1,241.0	15,382.6
10	"Багануур, зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ" ХК	5,379.0	1,386.0	65.0	6,830.0
11	"Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ" ХК	817.0	800.0	500.0	2,117.0
12	"Улаанбаатарын дулааны сүлжээ" ХК	8,000.0	5,000.0	3,500.0	16,500.0
13	"Дарханы дулааны сүлжээ" ХК	4,000.0	4,987.9	2,763.5	11,751.4

14	"Багануурын дулааны станц" ХК	3,380.1	5,150.0	-	8,530.1
15	"Налайхын дулааны станц" ХК	518.3	1,500.0	500.0	2,518.3
16	"Даланзадгадын дулааны цажилгаан станц" ХК	1,000.0	800.0	-	1,800.0
17	"Диспетчерийн үндэсний төв" ХХК	700.0	600.0	-	1,300.0
Дүн		107,976.0	98,548.3	52,739.5	259,263.8

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2009 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр

Дугаар 21

Улаанбаатар хот

Татварын алдангийн хувь хэмжээг тооцох тухай

Татварын ерөнхий хуулийн 60.2-ыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Хуулиар тогтоосон хугацаанд төлөөгүй болон татварын алба, татварын улсын байцаагчийн буруутай шийдвэрийн дагуу татвар төлөгчөөс үндэслэлгүй, илүү хураасан татварт тооцох алдангийн хувь хэмжээг хоног тутамд 0.06 хувиар тогтоосугай.

2. Энэ тогтоолын 1 дүгээр зүйлд заасан

алданги тооцох хувь хэмжээг 2008 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг Татварын ерөнхий газрын дарга Ц.Оюунбаатарт даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**
С.БАЯР
САНГИЙН САЙД
С.БАЯРЦОГТ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2009 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр

Дугаар 22

Улаанбаатар хот

Татварын маргаан таслах зөвлөлийн ажиллах журам батлах тухай

Татварын ерөнхий хуулийн 19.3-ыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Татвар төлөгч, татварын албаны хооронд үүссэн маргааныг хянан шийдвэрлэх эрх бүхий "Татварын маргаан таслах зөвлөлийн ажиллах журам"-ыг хавсралтын ёсоор баталсугай.

2. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сангийн сайд С.Баярцогтод үүрэг болгосугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Журам батлах тухай" Засгийн газрын 1999 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 189 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**
С.БАЯР
САНГИЙН САЙД
С.БАЯРЦОГТ
Засгийн газрын 2009 оны 22 дугаар тогтоолын хавсралт

ТАТВАРЫН МАРГААН ТАСЛАХ ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэр, Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь татварын акт, дүгнэлтэй холбоотой гомдол (цаашид "гомдол" гэх)-ыг хянан шийдвэрлэхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.

1.2. Маргаан таслах зөвлөл нь татварын акт, дүгнэлтэй холбоотой гомдол (цаашид "гомдол" гэх)-ыг хянан шийдвэрлэхдээ энэ журам болон Татварын ерөнхий хууль, Захиргааны хариуцлагын тухай хууль, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийг удирдлага болгоно.

1.3. Маргаан таслах зөвлөл нь үйл ажиллагаандаа хууль дээдлэх, бусдын нөлөөнд үл автах, татвар төлөгчийн болон татварын албаны хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх, татвар төлөгчийн нууцыг чанд хадгалах зарчим баримтална.

1.4. Маргаан таслах зөвлөл нь Татварын ерөнхий газрын дэргэдэх Маргаан таслах зөвлөл, аймаг, нийслэлийн татварын газар, хэлтсийн дэргэдэх Маргаан

таслах зөвлөлөөс бүрдэнэ. Маргаан таслах зөвлөл нь орон тооны бус байна.

1.5. Маргаан таслах зөвлөл нь гомдлыг Татварын ерөнхий хуулийн 42.1-д заасан үндэслэлээр хянан шийдвэрлэнэ.

1.6. Татвар төлөгч нь гомдлоо тухайн татварын акт, дүгнэлт бичсэн татварын улсын байцаагчийн шууд харьяалах татварын албаны дэргэдэх Маргаан таслах зөвлөлд, аймаг, нийслэлийн татварын газар, хэлтсийн дэргэдэх Маргаан таслах зөвлөлийн шийдвэртэй холбоотой гомдлоо Татварын ерөнхий газрын дэргэдэх Маргаан таслах зөвлөлд, Татварын ерөнхий газрын дэргэдэх Маргаан таслах зөвлөлийн шийдвэртэй холбоотой гомдлоо шүүхэд тус тус бичгээр гаргана.

1.7. Гомдол нь Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан байна.

1.8. Гомдлыг Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан журмын дагуу хянан үзнэ.



1.9. Гомдлыг Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өгөөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасан үндэслэлээр хянан үзэхгүй байх буюу буцаана. Гомдлыг хянан үзэхгүй байх буюу буцаахаа шалтгаан, үндэслэлийг тодорхой зааж, албан бичгээр мэдэгдэнэ.

1.10. Маргаан хянан шийдвэрлэх үйл ажиллагаатай холбогдох зардлыг тухайн маргаан таслах зөвлөлийг харьяалж байгаа татварын алба хариуцна. Маргаан таслах зөвлөлийн гишүүдэд хуралдсан цагаар нь хөлс олгоно. Цагийн хөдсний хэмжээг тухайн Маргаан таслах зөвлөлийн гишүүдийг томилсон эрх бүхий албан тушаалтан тогтооно.

Хоёр. Маргаан таслах зөвлөлийн бүрэн эрх

2.1. Маргаан таслах зөвлөл дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

2.1.1. гомдлыг харьяаллын дагуу хянан шийдвэрлэх;

2.1.2. гомдлыг хянан шийдвэрлэхэд шаардлагатай баримт бичиг, мэдээ, судалгааг холбогдох этгээдээс гаргуулж авах, гомдлыг хянан шийдвэрлэсний дараа авсан материалаа буцааж өгөх;

2.1.3. татвар төлөгч, татварын улсын байцаагч болон холбогдох бусад этгээдээс тайлбар, нотлох баримт гаргуулж авах;

2.1.4. шаардлагатай тохиолдолд орчуулагч, шинжээч ажиллуулах;

2.1.5. хянан шийдвэрлэж байгаа асуудал нь гэмт хэргийн шинжтэй бол зохих журмын дагуу хууль хяналтын байгууллагад шилжүүлэх;

2.1.6. татварын акт, дүгнэлт хууль зүйн үндэслэлгүй болох нь тогтоогдвол түүнийг бичсэн татварын улсын байцаагчид Татварын ерөнхий хуулийн 73.2-т заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулах саналыг Татварын ерөнхий газрын даргад тавих.

Гурав. Гомдол хянан шийдвэрлэх ажиллагаанд

бэлтгэх

3.1. Маргаан таслах зөвлөл нь гомдолд магадлагаа хийж дүгнэлт гаргах үүрэг бүхий татварын улсын байцаагч (цаашид "магадлагч" гэх)-тай байна.

3.2. Аймгийн татварын хэлтсийн дэргэдэх Маргаан таслах зөвлөлийн магадлагчийг тухайн татварын албаны даргын, Татварын ерөнхий газар болон нийслэлийн татварын газрын дэргэдэх Маргаан таслах зөвлөлийн магадлагчийг Татварын ерөнхий газрын даргын тушаалаар тус тус 3 жилийн хугацаагаар томилно. Магадлагчаар нэг удаа улируулан томилж болно.

3.3. Магадлагчийг Татварын ерөнхий газрын даргын тушаалаар баталсан журмын дагуу сэлгэн ажиллуулж болно.

3.4. Аймаг, нийслэлийн татварын газар, хэлтсийн дэргэдэх Маргаан таслах зөвлөлөөр гомдол хянан шийдвэрлэхэд оролцсон магадлагч тухайн гомдлыг Татварын ерөнхий газрын дэргэдэх Маргаан таслах зөвлөлөөр хянан шийдвэрлэхэд оролцохыг хориглоно.

3.5. Магадлагч нь үйл ажиллагаандаа энэ журам болон татварын хууль тогтоомж, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Сангийн сайдын баталсан журам, заавар, Засгийн газрын 1997 оны 177 дугаар тогтоолоор баталсан "Шүүх нягтлан бодох бүртгэлийн магадлагаа хийх дүрэм"-ийг удирдлага болгоно.

3.6. Маргаан таслах зөвлөлийн нарийн бичгийн дарга нь хуралдаан болохоос 2-оос доошгүй хоногийн өмнө зөвлөлийн дарга, гишүүдэд хуралдааны тов, төлөвлөгөө болон хэлэлцэх асуудлын танилцуулга, материалыг хүргэнэ.

3.7. Маргаан таслах зөвлөлийн нарийн бичгийн дарга нь энэхүү журмын 3.1-д заасан чиг үүргийг дангаар болон магадлагчтай хамтран хэрэгжүүлж болно. Энэ

тохиолдолд Маргаан таслах зөвлөлийн нарийн бичгийн дарга үйл ажиллагаандаа энэ журмын 3.4, 3.5-д заасан зарчмыг удирдлага болгоно.

Дөрөв. Гомдол хянан шийдвэрлэх ажиллагаа

4.1. Маргаан таслах зөвлөл нь энэ журмын 1.7-д заасан шаардлагыг хангасан гомдлыг хуульч авснаас хойш 30 хоногийн дотор хянан шийдвэрлэх бөгөөд зайлшгүй шаардлагатай гэж үзвэл зөвлөлийн дарга уг хугацааг нэг удаа 30 хүртэл хоногээр сунгаж болно.

4.2. Маргаан таслах зөвлөлийн хуралдаанд маргааны оролцогч талууд болон Маргаан таслах зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга, гишүүд болон магадлагч оролцоно. Хуралдааныг гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь оролцсоноор хүчинтэйд тооцно.

4.3. Хуралдааныг Маргаан таслах зөвлөлийн дарга даргална. Маргаан таслах зөвлөлийн даргын тур эзгүй үед хуралдааныг Маргаан таслах зөвлөлийн даргын үүрэг болгосноор түүний үүргийг түр гүйцэтгэх зөвлөлийн аль нэг гишүүн даргална.

4.4. Хуралдаанд хэлэлцүүлэх асуудлыг магадлагч, энэ журмын 3.7-д заасан тохиолдолд Маргаан таслах зөвлөлийн нарийн бичгийн дарга оруулна.

4.5. Хуралдаанд Маргаан таслах зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга, гишүүд таслах /батлах/ эрхтэй оролцоно. Хуралдааны үйл ажиллагаанд тус зөвлөлийг харьяалж байгаа татварын албаны дарга зөвлөх эрхтэйгээр оролцож болно. Энэ тохиолдолд хэлэлцэж байгаа асуудлын талаар тухайн татварын албаны даргын саналыг заавал сонсоно.

4.6. Хуралдаанаар хэлэлцсэн асуудлын талаархи шийдвэрийг олонхийн саналаар гаргана.

4.7. Маргаан таслах зөвлөлийн хуралдааны товыг маргааны оролцогч талуудад зарласан боловч тэдгээр нь хүндэтгэн үзэх шалтгаан /өвчтэй байсан, гадаад буюу орон нутагт томиллоор явсан/-гүйгээр хуралдаанд ирээгүй нь гомдлыг хуралдаанаар хэлэлцэн шийдвэр гаргахад саад болохгүй.

4.8. Маргаан таслах зөвлөлийн нарийн бичгийн дарга нь зөвлөлийн дотоод ажлыг хариуцна. Нарийн бичгийн дарга нь зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэх асуудлын болгээлийг хангаж, хуралдааны тэмдэглэлийг хөтөлнө. Хуралдааны тэмдэглэлд Маргаан таслах зөвлөлийн дарга болон нарийн бичгийн дарга гарын үсэг зурна. Маргаан таслах зөвлөлийн даргын тур эзгүйг хуралдааны тэмдэглэлд түүний үүргийг түр гүйцэтгэж байгаа зөвлөлийн аль нэг гишүүн гарын үсэг зурна.

Тав. Маргаан таслах зөвлөлийн шийдвэр

5.1. Маргаан таслах зөвлөл гомдлыг хянан хэлэлцээд дараахь шийдвэрийн аль нэгийг гаргана:

5.1.1. татварын акт, дүгнэлтийг өөрчлөх;

5.1.2. татварын акт, дүгнэлтийг хүчингүй болгох;

5.1.3. татварын акт, дүгнэлтийг хэвээр үлдээх.

5.2. Маргаан таслах зөвлөлийн шийдвэрийг хуралдаанд оролцогчдоод уншиж сонсоно. Ингэхдээ тухайн шийдвэрийг эс зөвшөөрвөл дээд шатны татварын албаны дэргэдэх Маргаан таслах зөвлөл буюу шүүхэд гомдол гаргах эрхийг нь татвар төлөгчид тайлбарлана.

5.3. Маргаан таслах зөвлөлийн шийдвэр нь тогтоол хэлбэртэй байх бөгөөд тогтоолд зөвлөлийн дарга, гишүүд гарын үсэг зурна.

5.4. Тогтоол нь удиртгал, тодорхойлох, үндэслэх, тогтоох хэсгээс бүрдэнэ.

Удиртгал хэсэгт тогтоолыг хэзээ, хаана, ямар Маргаан таслах зөвлөл гаргаж байгаа, хурлын дарга, оролцсон гишүүд, нарийн бичгийн дарга, маргааны оролцогч талуудыг нэрлэн заана. Тодорхойлох хэсэгт гомдлын шаардлага, маргааны оролцогч талуудын тайлбарын агуулга, магадлагчийн дүгнэлтийг заана.



Үндэслэх хэсэгт гомдлыг хянан шийдвэрлэхэд үндэс болсон нотлох баримтын хууль зүйн болон бодит үндэслэл, түүнийг Маргаан таслах зөвлөлөөс хэрхэн үнэлж байгаа тухай заана.

Тогтоох хэсэгт гомдлыг хянан шийдвэрлэхэд баримталсан хуулийн нэр, зүйл, хэсэг, заалтыг тодорхой зааж, гомдлын шаардлагыг хангасан, эсхүл зарим хэсгийг хангаж, зарим хэсгийг хэрэгсэхгүй болгосон, гомдлыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосон тухай тусгана.

5.5. Маргаан таслах зөвлөлийн шийдвэрийг 7 хоногийн дотор тухайн шатны татварын албаны даргад хүргүүлнэ. Татварын албаны дарга шийдвэрийг 3 хоногийн дотор тушаалаараа баталгаажуулна.

Татварын албаны дарга шийдвэрийг баталгаажуулах үндэслэлгүй гэж үзвэл шалтгааныг тодорхой тусгасан тайлбарын хамт Маргаан таслах зөвлөлд буцаана.

5.6. Маргаан таслах зөвлөл нь энэхүү журмын 5.5-д заасан татварын албаны даргын тайлбарыг хуралдаанаараа хэлэлцэн дараахь шийдвэрийн аль нэгийг гаргана:

5.6.1. тайлбарыг хүлээн зөвшөөрвөл өмнө гаргасан тогтоолоо өөрчлөх;

5.6.2. тайлбарыг эс зөвшөөрвөл Татварын ерөнхий газрын даргад тавьж шийдвэрлүүлэх.

5.7. Энэхүү журмын 5.8-д зааснаас бусад тохиолдолд Татварын ерөнхий газрын дарга мөн журмын 5.6.2-т заасан маргааныг хянан үзэж, татварын акт, дүгнэлтийг өөрчлөх, хүчингүй болгох, хэвээр үлдээх шийдвэрийн аль нэгийг гаргана.

5.8. Татварын ерөнхий газрын дарга энэхүү журмын 5.6.2-т заасан зарим тохиолдолд асуудлыг Татварын ерөнхий газрын дэргэдэх Маргаан таслах зөвлөлд шилжүүлэн шийдвэрлүүлж болно.

5.9. Маргаан таслах зөвлөлийн шийдвэр энэхүү журмын 5.5-ын 1 дэх өгүүлбэрт заасан тохиолдолд хүчэн төгөлдөр болно.

5.10. Маргаан таслах зөвлөлийн нарийн бичгийн дарга зөвлөлийн хүчин төгөлдөр шийдвэрийг, түүнийг баталгаажуулсан тухайн шатны татварын албаны даргын тушаалын хамт маргааны оролцогч талуудад гардуулна. Зөвлөлийн нарийн бичгийн дарга тогтоолыг гардуулсан тухай тэмдэглэл хийж, бүртгэнэ.

5.11. Маргааны оролцогч талууд аймаг, нийслэлийн татварын газар, хэлтсийн дэргэдэх Маргаан таслах зөвлөлийн шийдвэрийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор Татварын ерөнхий газрын дэргэдэх Маргаан таслах зөвлөлд уг шийдвэрийн талаар гомдол гаргаж болно.

5.12. Маргаан таслах зөвлөлийн хүчин төгөлдөр шийдвэрийг татвар төлөгч, татварын алба, татварын улсын байцаагч, албан тушаалтан биелүүлэх үүрэгтэй.

Зургаа. Гомдол хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчийн эрх, үүрэг

6.1. Гомдол хянан шийдвэрлэх ажиллагаанд татвар төлөгч, тухайн татварын акт, дүгнэлтийг бичсэн татварын улсын байцаагч оролцох бөгөөд тэдгээрийг маргааны оролцогч тал гэнэ.

6.2. Татвар төлөгчийн эрх, үүрэг:

6.2.1. татварын акт, дүгнэлт болон Маргаан таслах зөвлөлийн шийдвэртэй танилцаж, үндэслэлгүй гэж үзвэл гомдлоо энэхүү журмын 1.6-д заасан харьяаллын дагуу гаргах;

6.2.2. маргаантай татварын акт, дүгнэлттэй холбоотой тайлбар, нотлох баримтыг Маргаан таслах зөвлөлд гаргаж өгөх;

6.2.3. хуралдаанд оролцох буюу өөрийн төлөөлөгч, өмгөөлөгчийг оролцуулах;

6.2.4. хууль тогтоомжид заасан бусад эрх, үүрэг.

6.3. Татварын улсын байцаагчийн эрх, үүрэг:

6.3.1. Маргаан таслах зөвлөлийн шийдвэртэй танилцаж;

6.3.2. маргаантай татварын акт, дүгнэлттэй холбоотой тайлбар, нотлох баримтыг Маргаан таслах зөвлөлд гаргаж өгөх;

6.3.3. хуралдаанд оролцох;

6.3.4. хууль тогтоомжид заасан бусад эрх, үүрэг. Долоо. Сонирхлын зөрчил

7.1. Дараахь тохиолдолд Маргаан таслах зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга, гишүүн, магадлагч гомдол хянан шийдвэрлэх ажиллагаанд үл оролцох бөгөөд өөрөө татгалзан гарах үүрэгтэй.

7.1.1. маргааны оролцогч тал болох иргэн, татварын улсын байцаагчийн гэр бүл, төрөл садан бол;

7.1.2. маргааны оролцогч тал болох хуулийн этгээдийн хувьцаа эзэмшигч бол;

7.1.3. гэр бүл, төрөл садан нь маргааны оролцогч тал болох хуулийн этгээдийн эрх бүхий этгээд (Төлөөлөн удирдах зөвлөл, хамтын гүйцэтгэх удирдлагын гишүүн, гүйцэтгэх захирал, санхүүгийн албаны дарга, ерөнхий нягтлан бодогч, ерөнхий мэргэжилтэн) бол.

7.2. Энэхүү журмын 7.1-д заасан үндэслэлээр маргааны оролцогч тал Маргаан таслах зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга, гишүүн, магадлагчийг гомдол хянан шийдвэрлэх ажиллагаанаас татгалзан гаргах талаар хүсэлт гаргана. Хүсэлтийг зөвлөлд бичгээр ирүүлнэ. Маргаан таслах зөвлөл хүсэлтийг 2 хоногийн дотор шийдвэрлэнэ.

7.3. Аймаг, нийслэлийн татварын газар, хэлтсийн дэргэдэх Маргаан таслах зөвлөлийн гишүүдийн гуравны нэгээс дээш нь гомдол хянан шийдвэрлэх ажиллагаанаас татгалзан гарсан тохиолдолд гомдлыг Татварын ерөнхий газрын дэргэдэх Маргаан таслах зөвлөлд шилжүүлэн шийдвэрлүүлнэ.

7.4. Татварын ерөнхий газрын дэргэдэх Маргаан таслах зөвлөлийн гишүүд гомдол хянан шийдвэрлэх ажиллагаанаас татгалзан гарсны улмаас зөвлөлийн хуралдааны ирц бүрдэхгүй болсон тохиолдолд санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн татгалзан гарсан гишүүнийг чөлөөлж, шинээр томилоно. Ингэхдээ Татварын ерөнхий хуулийн 42.3-42.5-д заасан зарчмыг удирдлага болгоно.

7.5. Энэхүү журмын 7.3, 7.4-т заасан зарчмыг зөрчиж гаргасан Маргаан таслах зөвлөлийн шийдвэрийг хүчингүйд тооцно.

Найм. Бусад зүйл

8.1. Маргаан таслах зөвлөл гомдлыг хүлээн авсан нь татварын акт, дүгнэлтийн биелэлтийг тэдгээлүүлэх үндэслэл болохгүй.

8.2. Маргаан таслах зөвлөл нь маргааны оролцогч тал болох иргэн нас барсан тохиолдолд түүний өвчөгчийг, хуулийн этгээд өөрчлөн зохион байгуулагдсан тохиолдолд шинээр үүссэн хуулийн этгээдийг тэдгээрийн хүсэлтээр маргааны оролцогч талаар тооцож болно. Энэ тохиолдолд тухайн этгээд нь энэ журмын 6.2-т заасан эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас эрхлэн гаргав.
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> сэтгүүлийн редакци.

Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэлэлцэх хэсэгт хэвлэв.

Улаанбаатар-12
Төрийн ордон-128 тоот

☎ 262420, 329612
Индекс 14003

☎ 329487

Хэвлэлийн хуудас 1